

2013.10 Дугаар 6

 Follow Up төслийн шалгаруулалтын дүн

 Project E-News


【SATREPS - Төсөл】

Төслийн удирдагч Такэцүрү Эйко

 Volunteer E-News

【Завхан аймгийн Эрүүл мэндийн газарт эх баригчаар томилогдон ажиллаж байгаа Залуу сайн дурын гишүүн Үмэда Михо-гийн сэтгэгдэл】

*Сайн дурынхныг хариуцсан
ажилтан Э. Золбоо*

 Сургалт төгсөгчийн булан

【ЖАЙКА-гийн Сургалт Төгсөгчдийн Холбоо】

Холбооны нарийн бичгийн дарга Л. Дондог

Бэлтгэсэн : П. Алтансүх

Жайка Монгол дахь төлөөлөгчийн газар
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3,
Улаанбаатар хот
Утас: 976-11-325939, 312393
Факс: 976-11-310845
E-mail: mg_oso_rep@jica.go.jp
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

Сайн байцгаана уу эрхэм төгсөгчдөө!

Та бүхэнд зориулан гаргадаг цахим сонингийн энэ дугаарыг хүргэж байна.

• Сургалтын үеэр бичиж байсан “үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлт болон сургалтын үр дүнд суурилсан таны цаашдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалт семинар зохион байгуулах **2013 Follow Up** төслийн шалгаруулалт амжилттай явагдаж дууслаа. Энэ удаагийн шалгаруулалтаар доорх 3 семинарын сэдэв сонгогдсон.

1. “Улаанбаатар хотын өрхийн эмнэлэг болон дүүргийн эмнэлгүүдийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын вирус гепатитын мэдлэгийг дээшлүүлэх, эхээс урагт халдварлах эрсдлийг бууруулах” ХӨСҮТөвийн Чанарын менежер О.Сумьяа, ХӨСҮТөвийн Хүлээн авах яаралтай тусламжийн тасгийн эмч Б.Батсүх
2. “NAMHEM-ийн орон нутгийн лабораторт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэх” Цаг уур Орчны шинжилгээний газар, Орчны шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Энхмаа
3. “Хүнсний аюулгүй байдал” Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нэгдсэн төв лаборатори, Эрүүл ахуйн шинжээч Д.Сайнжаргал

Семинартай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг ЖАЙКА-гийн Төлөөлөгчийн Газраас авна уу.

• ЗАРЛАЛ:

Монгол дахь ЖАЙКА-гийн Төлөөлөгчийн Газар өөрийн Facebook-тэй боллоо. Та өөрийн сонирхсон төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг эндээс авах боломжтой.



The screenshot shows a Facebook post from JICA Mongolia dated October 17. The post is in Japanese and describes a school opening ceremony for a primary school in a rural area. It mentions that the school was built with JICA funds and that there were 54 students. The post includes a photo of the school building and a photo of the ceremony. The post has 224 likes and 9 comments.

<https://www.facebook.com/pages/JICA-Mongolia/638581722827332?ref=profile>

SATREPS - Төсөл

Төслийн удирдагч Такэцүрү Эйко

【Төслийн танилцуулга】

SATREPS гэдэг нь *Science and Technology Research Partnership for Sustainable Development* буюу “Дэлхий даяар тулгамдаж буй асуудлыг шийдэхэд чиглэсэн олон улсын шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагаа”-ны товчлол бөгөөд JST буюу Японы Шинжлэх ухаан технологийн хөгжлийн агентлаг болон ЖАЙКА (Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага) хамтран хэрэгжүүлдэг эрдэм шинжилгээний хамтарсан хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн хүрээнд Япон болон хөгжиж буй орнуудын судлаачид дэлхий дахинд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх хамтарсан эрдэм шинжилгээний төслийг 3-5 жилийн хугацаатай хэрэгжүүлдэг.

SATREPS төсөл нь зөвхөн нэг улс, бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх боломжгүй дэлхий даяараа тухайн асуудалтай тэмцэх шаардлагатай тулгамдсан асуудлууд болох байгаль орчин, эрчим хүч, байгалийн гамшиг, халдварт өвчин болон хүнсний асуудлыг шийдвэрлэх, түүнд чиглэгдсэн хамтарсан эрдэм шинжилгээний ажлыг явуулдагаараа онцлог юм.

2013 онд шинээр батлагдсан “Монгол оронд тохиолддог малын цусны шимэгч, эгэл биетнээр үүсдэг өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой арга боловсруулах нь” төсөл нь Монгол улсын хэмжээнд анх удаа хэрэгжих SATREPS төсөл болж байгаа бөгөөд цаашид 5 жилийн хугацаанд (2014оны бсар – 2019оны 5сар) хамтарсан эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийх юм. Энэхүү төслийн Монгол дахь хэрэгжүүлэгч байгууллагаар Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Мал эмнэлгийн хүрээлэн, Япон талын хэрэгжүүлэгч байгууллагаар Обихиро Хөдөө аж ахуй, Мал эмнэлгийн их сургууль, Эгэл биет судлалын үндэсний төв тус тус оролцож байгаа бөгөөд хамтарсан эрдэм шинжилгээний

ажлын хүрээнд өвчний тархалтын судалгаа, оношилгооны оновчтой, үр дүнтэй аргыг боловсруулах замаар малын эгэл биет, цусны шимэгчээр үүсгэгддэг трипаносомы, пироплазма зэрэг өвчний эрт үеийн оношилгоо ба түүнээс урьдчилан сэргийлэх арга боловсронгуй болоод зогсохгүй судалгаа шинжилгээний чадамж улам дээшлэх ач холбогдолтой юм.



Энэхүү хоёр байгууллага нь өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд хамтран ажиллаж ирсэн туршлагатай бөгөөд энэ хоёр байгууллагын харилцан ойлголцлын үндсэн дээр төсөл маань амжилттай хэрэгжих нөхцөл бүрдээд байгаа юм. Мөн энэ удаагийн төсөл нь нэгэн хугацаанд зэрэг хэрэгжих техникийн хамтын ажиллагааны “Мал эмнэлэг, мал аж ахуйн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах төсөл”-тэй хамтран Монгол улсын мал эмнэлэг, мал аж ахуйн салбарт мэдлэг чадвартай боловсон хүчнийг бэлтгэн гаргах ажилд хувь нэмрээ оруулах юм.

Энэ удаагийн Сайн дурын гишүүний буланд Завхан аймгийн Эрүүл мэндийн газарт эх баригчаар томилогдон ажиллаж байгаа Залуу сайн дурын гишүүн Үмэда Михо-гийн сэтгэгдэл болон ажлын тухай танилцуулахаар бэлтгэлээ. Үмэда Михо гишүүн нь Завхан аймгийн Эрүүл мэндийн газарт НҮБ-н Хүн амын сангийн шугамаар хэрэгжиж буй Нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах төсөлтэй хамтран ажиллахаар 2013 оны 1 сарын 7 өдрөөс 2015 оны 1 сарын 06 өдөр хүртэл 2 жилийн хугацаатай Завхан аймгийн Эрүүл мэндийн газарт эх баригчаар томилогдон ажиллаж байна. Ингээд Үмэда Михо гишүүний сэтгэгдлийг хүргэе.

Үмэда Михо: Одоогийн хийж байгаа ажлынхаа талаар товч танилцуулбал ажлын өдөр үдээс өмнө аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт эх баригч эмчтэй хамтран ажиллаж, үдээс хойш нь Эрүүл мэндийн газарт НҮБ хүн амын сангийн төслийн зохицуулагчын сургалтад туслахын зэрэгцээ монгол хэлний бэлтгэл хичээлд суун өдрийг үр бүтээлтэй өнгөрүүлэхийг зорьж байна.

Миний олж харсанаар эмнэлэгийн эмч сувилагч нарын мэргэжлийн ур чадвар маш өндөр, эх барих арга барилын хувьд японд баримталдаг арга барилаас ялгагдахааргүй санагдсан. Кесарево хагалгаа хийх ур чадвар ч гэсэн өндөр юм. Японд сүүлийн үед төрөлтийн нас өндөрсөж, жирэмсний үеийн даралт ихдэлт зэрэг жирэмсэн эхчүүдэд тохиолддог эрсдэлүүд нэмэгдсээр байгаа тул кесарево хагалгаа хийх тоо ч гэсэн өсөж байгаа.

Монгол дахь жирэмсэн эмэгтэйчүүдэд тохиолддог нийтлэг үзэгдэлд хавагналт, жингийн нэмэгдэл их байдаг. Тиймээс миний зүгээс хийж чадах зүйл бол Монголын уламжлалт хоолны соёлыг хадгалангаа байгаа нөөцөө ашиглан жирэмсэн эхчүүдэд эрүүл хоололтын талаарх заавар зөвлөгөө өгөх явдал юм. Эрүүл хоололт, дасгал хөдөлгөөний заавар зөвлөгөө өгснөөр бага ч болов хавагналт, жингийн нэмэгдэлийг арилгаж

чадах юм шиг санагдаж байна.

Цаашдын ажлын төлөвлөгөөний тухайд гэвэл 2013 оны 1 сараас хойш өнгөрсөн 10 сарын хугацаанд төрөх тасагт ажиглаж, хийж ирсэн туршлага болон Завхан аймгийн Эрүүл мэндийн газраас тавьсан хүсэлтэд үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан.

Төлөвлөгөөт ажлын биелэлтийг хангах тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх болно. Үүнд:

1. Жирэмсэн эхчүүдэд зориулсан сургалт зохион байгуулах
2. Эх хүүхдийн хяналтын картыг өргөн хэрэглээ болгох
3. Японы төрөхтэй холбоотой эмчилгээний талаар танилцуулга хийх
4. Залуу охид, бүсгүйчүүдэд зориулсан жирэмслэлтийн талаарх мэдлэг, гэр бүл төлөвлөлтийн тухай семинар зохион байгуулах.

Төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн холбогдох хүмүүстэй хамтран ажиллаж, тэдний туслалцаатайгаар хэрэгжүүлж чадна гэж бодож байна.



Сургалт төгсөгчийн булан

Жайка-гийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

ЖАЙКА-гийн сургалт төгсөгчдийн холбооны гол зорилго нь ЖАЙКА байгууллагын шугамаар Япон улсад суралцагсдын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг Монгол улсын хөгжилд зориулах, мөн Монгол Японы хоорондын техникийн болон бусад хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Тус холбоо 2000 онд байгуулагдсан 740 гишүүнтэй. Холбооны тэргүүнээр УИХ-ын гишүүн Оюунбаатар ажиллаж байна.

Жил бүр ЖАЙКА байгууллагын шугамаар суралцагчдын нилээд хэсэг нь манай холбоонд гишүүнээр элсдэг бөгөөд Япон улсад суралцаж, мэргэжил дээшлүүлсэн мэргэжилтнүүд сурч мэдсэн зүйлээ олон түмэнд түгээх, сурталчилах сонирхолтой байдаг. Тэдний энэ сонирхлыг дэмжин жил бүр 4-8 төслийг сонгон шалгаруулж олон хүнийг хамруулсан семинар, сургалт зохион байгуулахад нь санхүү, зохион байгуулалтын тусламж үзүүлдэг.



Мөн холбооны гишүүд мод тарих, Туул голыг цэвэрлэх зэрэг эко арга хэмжээнд хамрагдан хоорондоо танилцаж, найз нөхөд болдог.



Холбооны үйл ажиллагааг үндсэнд нь ЖАЙКА байгууллага санхүүжүүлж байдагт нь холбооны гишүүд ихэд талархаж байдаг.

Холбооны хурлыг жил бүр хийж удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгч, сонгуулт хугацаа нь дуусч гарсан УЗ-ийн гишүүнийг нөхөн сонгодог. УЗ-ийн хурлыг жилд 6-8 удаа хийж цаг үеийн асуудлыг хамтран шийдвэрлэдэг.

Холбооны тэргүүн, Ерөнхий нарийн бичгийн дарга, УЗ-ийн гишүүд нь ямар нэгэн цалин урамшуулалгүй, өөрсдийн итгэл үнэмшил, идэвхи санаачлагаараа ажилладаг.

